

“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН БАЙНГЫН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД ТАВИХ ШАЛГУУР

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү шалгуур нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”, “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд арилжаа зохион байгуулах, биржийн үйл ажиллагааны найдвартай, эрсдэлгүй байдал, үндсэн зарчмыг хангахад чиглэсэн үндсэн шаардлага мөн.
- 1.2. Тус шалгуурыг Биржийн гүйцэтгэх удирдлага батлах бөгөөд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр нийтэд мэдээлнэ.

Хоёр. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 2.1. Байнгын гишүүнээр элсэх өргөдөл /биржийн маягтаар/.
- 2.2. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажсан хуулбар.
- 2.3. Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажсан хуулбар.
- 2.4. Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан, компанийн хувь нийлүүлэгчдийн лавлагаа, охин. компанид хөрөнгө оруулалт хийсэн толгой компанийн хувь нийлүүлэгчдийн лавлагаа.
- 2.5. Эрх бүхий албан тушаалтан, энэхүү баримт бичгийн 3.3-т заасан чиг үүрэг бүхий ажилтнуудын анкет нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар /анкет биржийн маягтаар/.
- 2.6. Арилжаанд оролцох эрх олгох ажилтантай байгуулсан нууцлалын гэрээ /эрх бүхий ажилтны гарын үсэг бүхий албан бичиг/.
- 2.7. Энэхүү бичиг баримтын 4.1-т заасныг нотлох гэрэл зураг.
- 2.8. Байгууллагын “Бизнес төлөвлөгөө” /3-5 жилээр/.
- 2.9. Сүүлийн нэг жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, үйл ажиллагаа эхэлж байгаа бол эхлэлтийн тайлан.
- 2.10. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга/шаардлагатай тохиолдолд/.
- 2.11. Санхүүгийн бичиг баримт дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажсан хувь /биржийн маягтаар/.
- 2.12. Элсэлтийн болон суудлын хураамж төлсөн баримт.
- 2.13. Биржийн гишүүний анкет /биржийн маягтаар/.

Гурав. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

- 3.1. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 10.4-т заасны дагуу, эрхбүхий байгууллагаас зуучлалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан байна.
- 3.2. Брокерууд нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 5.1.5-д заасны дагуу сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 3.3. Байнгын гишүүн оролцогч брокерын компанийн зохион байгуулалтын бүтцэд дараах чиг үүргийн ажилтан зайлшгүй байна. Үүнд:
 - 3.3.1. Харилцагчдад биржийн зах зээлийн мэдээлэл өгөх, тайлбарлах, компанийг төлөөлж биржтэй харилцах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх;
 - 3.3.2. Арилжигч брокер буюу гишүүн оролцогчийн арилжааг зохион байгуулах;
 - 3.3.3. Захиалгын брокер буюу харилцагчийн захиалгыг бүртгэж, арилжаанд оруулах;
 - 3.3.4. Барааны брокер буюу агуулах дахь барааны чанар, стандарт хариуцагч брокер.

Дөрөв. АЖЛЫН БАЙР БОЛОН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- 4.1. Байнгын гишүүн оролцогч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай ажлын байртай байх ба харилцагчийг хүлээн авч үйлчлэх танхимыг тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байна.
- 4.2. Биржээс заасан дараах техникийн шаардлагыг хангасан компьютер, техник хэрэгслийг ажлын байранд суурилуулсан байна. Үүнд:
 - 4.2.1. Арилжааны бүрэн эрхтэй программ;
 - 4.2.2. Арилжааны хагас эрхтэй программ;
 - 4.2.3. Харилцагчийн бүртгэлийн программ;
 - 4.2.4. Агуулахын бүртгэлийн программ;
 - 4.2.5. Биржийн арилжааны мэдээг харилцагчид түгээх мэдээллийн дэлгэц, хэвлэх төхөөрөмж;
 - 4.2.6. Интернэт холболт.

Тав. АГУУЛАХ

- 5.1. Байнгын гишүүнээр элсэх хүсэлт гаргагч нь орон нутагт байршилтай бол биржээр арилжих бараа, түүхий эдийг хадгалах, агуулахтай байх ба Биржийн байнгын гишүүн оролцогч болсон тохиолдолд Биржээр итгэмжлүүлнэ.
- 5.2. Улаанбаатар хотод байршилтай Байнгын гишүүн нь Биржийн итгэмжлэгдсэн агуулахтай гэрээ байгуулсан байна.